

ОРОС УЛСТАЙ ТОГТСОН ХАРИЛЦААНЫ ҮҮДНЭЭС МОНГОЛ УЛСЫН ТҮҮХИЙГ АВЧ ҮЗЭХ НЬ

*А.С.ЖЕЛЕЗНЯКОВ**

Орос болон Монгол улсын хоорондын харилцаа түүхийн турш өвөрмөц шинж чанартай байлаа. Байгалийн онцгой эсрэг тэсрэг бүс нутагтай, хосгүй соёл иргэншилтэй, баялаг түүхтэй Монгол улсыг типологийн талаас өөр ямар ч улстай нэг эгнээнд тавьж болохгүй. Эх газрын эрс тэс уур амьсгалтай бүс нутагт оршдог бөгөөд ойр болон холын нэг ч хөрш улстай адилтгаж болохгүй нүүдэлчин малчид болон хотын оршин суугчдын энэ улс нүүдлийн уламжлал болон аж үйлдвэрийн технологийг хослуулж чадсан хосгүй өвөрмөц улс юм.

Орос, Монгол улсын харилцааны түүхийн эхлэл бол олон зуун жилийн тэртээ, улс орны орчин цагийн нэр болон хил хязгаар ч байгаагүй, Хангай, Хэнтийн уулсын хөндийд төв нь үүсэн байгуулагдсан Евразийн нүүдлийн эзэнт улсууд оршин тогтнож байсан тэр цаг үед тавигджээ. Орчин үеийн Орос улсын нутагт оршин сууж байсан улс түмэн болон гунн, авар /обр/, пюрк, монгол, халимаг зэрэг тэдгээр эзэнт улсаас гаралтай үндэстнүүдийн хоорондын харилцааны түүх нэг талаас цус асгаруулсан дайн, нөгөө талаас бат бэх цэргийн холбоогоор баялаг билээ. Евразийн нэгдмэл энэ бүс нутагт эдгээр нүүдлийн эзэнт улс ирээдүйн Орос улсын улс түмний үндэстэн хоорондын харилцаа холбоо, аж ахуй, соёлын нэгдмэл орон зай, улс төрийн харилцан шалтгаалах байдлын үндэс суурь тавьж байсан юм.

XIII зууны үед Оросын нутаг Монголын эзэнт улсын хэсэг болсон билээ. Оросын ноёд түшмэл Монголын нийслэл Хар Хоринд /Каракорум/ хуралтайд суухаар ирдэг байв. Монголын Хангайн нутагт тэд монголчуудын цэргийн байлдааны арга барилтай танилцаж, хааны ордны нууц явуулгад оролцож, хүн төрөлхтний түүхэнд хамгийн том энэ эзэнт улсын төр барих ухаанаас суралцдаг байлаа. Монголын хаад дэлхийн бүх зочин гийчдийн дотроос Оросын ноёдыг онцгой элэгсэг дотноор хүлээн авч, хамгийн хүндэтгэлтэй суудалд суулгадаг байлаа. Чухам үүнээс Алтан ордны хаад зэрэг Монголын хаад болон Оросын ноёд, тухайлбал Александр Невскийн хооронд анд бололцох ёс гаралтай билээ. Гэвч хаадын халуун хайр сэтгэл хар санаа хоёр

* А.С.Железняков – ОХУ-ын Дорнодахины хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, дэд доктор

хамт явдаг билээ. Жишээ нь, Александр Невскийн эцэг их ноён Ярослав Всеволодовичийг засгийн эрхэнд байсан Турэгэнэ /Туракина/ хатан хор өгч алсан түүхтэй. Монголын дарлалын эсрэг тэмцэж түүнээс чөлөөлөгдсөн явдал Орос улсын түүхийг “монголын хүчин зүйлээс” чөлөөлж чадаагүй. Тэр нь олон жилийн дараа Оросын бүх нутаг хүчирхэг нэг улсад нэгдэж, Европын хязгаараас хол тэлж, Орос улс Евразийн болон дэлхийн их гүрэн болж хувирахад ихээхэн нөлөө үзүүлсэн билээ.

XVII зууны үед Орос улсын хил хязгаар Монголын тулгуур нутагт ойртсон билээ. Монгол нь тэр үед тархай бутархай хэдэн улсад хуваагдаж, түүхийнхээ явцад олон удаа оршиж байсан “замын уулзварт” байлаа. Өмнөх түүхэнд Монголын зүрх нутаг болох давагдашгүй уулс, шигүү ой хөвч, зэлүүд говь, хязгааргүй тал нутгаар бэлчээр нь хүрээлэгдсэн Хангай-Хэнтийн орныг гартаа авч чадсан чухам тэр хаан төрийн эрхэнд гарч тархай бутархай байдал төгсдөг байлаа. Тулгуур нутгийг эзэлсэн тэдгээр хаад Монголоос гадна Манж, Өвөр Монгол, Шинжаан, Байгал орчмын нутаг зэрэг түүнийг тойрсон улс аймгийн эзэн болдог байжээ. Европт гунн гэсэн нэрээр алдаршсан хунну, жужан /Оросын түүхийн бичлэгт авар буюу обр гэсэн нэрээр гардаг/, түрэг, хятан, Чингис хааны цэрэг чухам эндээс цэргийн аян дайнаа эхэлдэг байсан билээ. Гэтэл энэ удаад эсгий туургатны бүх аймгууд Монголын голомтыг тойрон нэгдэж чадаагүй. Хойт хязгаарт нь Орос улс хэмээх шинэ хөрштэй болсон хойно тус бүс нутгийн хөгжлийн хэвийн үйл явц эрс өөрчлөгджээ.

Өмнөд нутгийн монголчууд Чин улсын бүрэлдэхүүнд орж, хойт зүгийн буриадууд Орос нутагт нэгдэж, өрнөдийн хямралдаанаас болж ойрдын хэсэг Зүүн гараас гарч Ижил мөрний хавьд нүүж Орос улсын бүрэлдэхүүнд Халимагийн хаант улсыг байгуулжээ. Зүүн гараас бас гаралтай хошууд Хөх нуурын орчим хаант улсаа тогтоожээ. 1640 онд Зүүн гар, Халх, Халимаг, Хөх нуурын 44 томоохон хаан ноёдын хуралтай /Зүүн гарын хуралтай/ болсон билээ. Гэвч Манж, Оросын эзэн хаадын талаас уран дипломат бодлого явуулсан учир энэ хурлын шийдвэрийг биелүүлж чадаагүй юм. Үүгээр Ази, Европт нүүдэлчдийн төлөвлөж байсан шинэ довтолгоог зогсоож чаджээ. Монгол улсын хөгжлийн чиглэл өөрчлөгдөв. Зүүн гарын хаант улс, Алтан хаадын улс, Халхын аймгууд зэрэг монгол нутаг дэвсгэрт оршиж байсан төр улсууд нь тулгуур нутгаас тасарч Орос болон Манжийн Чин улсын бүрэлдэхүүнд орсон нүүдэлчдийн улсуудын байр суурийг харгалзахгүй байж болохгүй болжээ.

Монгол улс арга барагдахад холбоотноо олж чаддаг байв. Манж, Орос, Төвдийн төр баригчидтай идэвхтэй холбоо харилцаа тогтоож, Монголын өвөрмөц шинж чанараа хадгалах шинэ арга зам

эрэн сүвэгчилж байлаа. Монголчууд өөрт нь шаардлагатай зүйлээ тал талаас олж чаддаг байсан билээ.

Манжийн эзэн хаан Чингис хааны хасбу тамгийг барьж үйл ажиллагааг нь жинхэнэ ёсоор үргэлжлүүлэх эрхийг эдлэх ёстойг монголчууд хүлээн зөвшөөрөхдөө, үгүй бол өөрийгөө хуурч, үгүй бол арга барагдаж байсан байх. Гэтэл Манжийн бүрэлдэхүүнд орсон хойно Монгол энэ эзэнт улсын хамгийн их тусгай эрх эдэлсэн хэсэг болж байсан нь үнэн юм. Монгол, Манж хоёрыг үндэстний нэгдмэл эв үүсвэр, аж ахуй, ахуй амьдралын ойр дөт байдал, хаад ноёдын хоорондоо гэрлэж байсан ёс заншил холбож байлаа. Монголчууд тус эзэнт улсад хятадуудаас илүү өндөр байр суурь эдэлж, өөрийн голомт тулгуур нутгийн хувь заяаны талаар сэтгэл зовохгүй байлаа. Энэ бол манжийн хувьд ч зуны үеэр амардаг газар, хятадуудын колончлолын өмнө хаалт тавьсан сүүлчийн өмөг түшиг болж байлаа. Монголчууд Орос улстай хил залгааг шалтаг болгон хил хязгаараа бэхжүүлэхэд шаардлагатай нэлээд хэмжээний хөрөнгө авч чаджээ. Үүний ачаар тус оронд тулгагдаж байсан Оросын колончлолыг зогсоож чадсанаар барахгүй, монгол ноёд тархай бутархай байдлаас гарах боломжтой болсон билээ. Нийт Монголын хилийн харуулыг зохион байгуулж, өртөө болон төвийн удирдлагатай бусад алба тогтоов. Манж хүн ам эцсийн эцэст Хятадын үндэстний дотор бүрэн ууссан боловч Чин улсын эзэн хааны ордноос олон жилийн турш Монголын өвөрмөц байдлыг хадгалахад чиглэгдсэн бодлогыг явуулж байлаа.

Манж улсын дотор эдлэж байсан тийм эрхийг Орос улс монголчуудад олгож чадахгүй байсан нь мэдээж. Харин Монголын ноёдын хувьд бол Орос улстай элчин гийчин солилцож байсан явдал Буриад, Халимагийн сургамжтай жишээг сайн мэдэж байсан Чин улсын эрх баригчдад нөлөө үзүүлэх сайхан хөшүүрэг болж байлаа. Түүнээс гадна Орос улс Монголын хувьд худалдааны чухал зах зээл болсон юм. “Сэлэнгинскийн шивээнд монголчууд хятадын бараа таваар ачсан тэмээн жинтэй ирж, оросын бараа таваараар сольж байгаа бөгөөд албаны хүмүүс болон Сэлэнгинскийнхэн тэд нартай байнга уулзаж худалдаа хийж байна” гэж Манжийн эзэн хаанд явуулсан захидалдаа Оросын элчин сайд Н.Г.Спафарий бичиж байлаа.

Буддын шашин тэр үеийн улс төрийн шинэ нөхцөл байдалд, Орос улс болон Хятадын Чин улсын талаас явуулж байсан эзэрхэг санаархалд Монголын өгсөн үзэл суртлын нэг ёсны хариулт боллоо. Монгол бол эртнээс христос, лал, будда болон күнзийн шашныг оролцуулан дэлхийн төрөл бүрийн соёл шашин шүтлэг нэвтэрч байсан нутаг байлаа. ХҮІ-ХҮІІ зууны зааг хүртэл олон мянган жилийн турш

Хангай-Хэнтийн бүс нутагт харь нутгийн нэг ч соёл, шашин хэвшиж чадаагүй байлаа. Энд бол бөөгийн шүтлэг, нүүдлийн эзэнт улсын мифлогемийн /тэнгэрийн шашин/ нийтлэг болсон соёл, шашны өөрийн хүчирхэг уламжлал давамгайлж байв. Монголчууд өөрийн нутагт буддын шашныг нэвтрүүлэхийн өмнө XIII-XVI зууны үед Төвд улсад чухал хэдэн шинэчлэл хийжээ. Тэд Юанийн эзэнт улсад буддын шашныг улсын шашин хэмээн зарлаж, төвдийн дээд лам нартай хамтран хааны засаг, шашны номыг хослуулсан хос ёс хэмээх ёсыг зохиожээ. Төвдийн үйл хэрэгт монголчуудын үзүүлж байсан нөлөө их хүчтэй байсныг дөрөвдүгээр далай лам Ёндонжамц /1588-1616/ монгол хүн байсан нь нотлон харуулж байна. Хэрэг дээр чухам монголчууд Төвдийг дэлхийн шашны төв болгоход хүчин чармайлт гаргаж байлаа. Энэтхэг, Төвдийн дараа Монгол улс нутаг дэвсгэртээ гэлдүгба буюу шарын шашны номыг дэлгэрүүлж, буддын шашны нэг ёсны "Туравдугаар Ром" болсон юм. Орон нутгийн нөхцөл байдалд тохируулсан шарын шашин Алтай, Тува, Буриад, Халимагт дэлгэрчээ. 1640 онд Түшээт хааны хүү Занабазарыг /Лувсандамбийжанцан, түүхэнд Өндөр гэгээн гэсэн нэрээр алдаршсан/ Өргөөний анхны хутагт, Монголын буддын шашны тэргүүнээр сонгосон явдал шинэ төрийн нийслэл бүрэлдэн тогтоход хүргэв. Монгол улс хамгаалагдсан хил хязгаартай, энхийг эрхэмлэсэн шашны тэргүүнтэй болсны үр дүнд ойрын болон холын улс орныг цэргийн хүчээр эзлэн түрэмгийлэх уламжлалт бодлогоосоо татгалзсан билээ. Буддын шашин нь Монголын соёлын амьдралыг энэ шашин урьд өмнө нь дэлгэрсэн орнуудын амьдралтай адил болгосонгүйгээр барахгүй, монголын соёл иргэншил болон өвөрмөц соёл хөгжихөд тогтвортой нөхцөл бүрэлдэн тогтоож, үүнд "хоёр дахь амьсгаа" өгсөн билээ. Нүүдлийн эзэнт улсууд оршиж байсан үед Монголд шинжлэх ухаан, урлаг, хот байгууламжийн салбарт богино хугацааны бөгөөд хүчтэй цэцэглэлт хөгжлийн дараа тус орон хоосорч, хаадын зуны амралтын газар, ан хийдэг газар болдог байлаа. Эзэнт улс бутарсны дараа тархай бутархай байдал, иргэний дайн, нэгдэхийн төлөө хөдөлгөөний үе шат эхэлдэг байжээ. Тийм нөхцөлд хотын соёлын элементүүд хаад ноёдын ордонгуудаар тарж бутархай байдалтай байсан юм. Нүүдлийн эзэнт улсаас уламжлан авсан цэргийн зохион байгуулалтаас иргэний засгийн эрхийн бүтцэд шилжсний үр дүнд эдийн засаг, нийгэм-ангийн бүтэц, улс төрийн систем, соёл, шинжлэх ухаан зэрэг Монголын нийгмийн амьдралын бүх чухал салбарт шинэчлэлт гарсан билээ. Шируун амьдралтай байсан цэргүүд мал аж ахуйн ухаанаа хөгжүүлж, ирээдүйн хотуудын суурь болсон сүм хийдийг барьж, боловсролтой бүрэн бүтэн ангийг тэжээж байсан нь юуны өмнө үйлдвэрлэлийн үр бүтээл өндөр түвшинд хүрч байсныг гэрчилнэ. Тус орны эрэгтэй хүн амын бараг тэн хагасыг эзэлж

байсан лам хувраг нийгмийн болон хүн амын өсөлтийн хувьд нэг ёсны зөөллүүр болж байв. Юу гэвэл тэд Буддын сургаалаар дайн дажныг эсэргүүцэж, гэрлэхээс татгалзаж байлаа.

Монгол улс бүхнийг хамарсан цэргийн татвар, цэргийн аян дайн, гадны колончлол, хүн амын хэт их өсөлт зэргийг баталгаатай зогсоож, хүн байгаль хоёр нарийн зохицсон тийм замаар хөгжиж эхэллээ. Дэлхийн хүн ам бохирдолгүй байгальд амьдарч, экологийн цэвэр хоол хүнс эдлэх гэсэн эрмэлзэлтэй байгаа өнөө үед энэ зохицол нь монгол хүний аж ахуй, улс төр, соёлын үйл ажиллагааг хосгүй явдал хэмээн үзэх боломж өгч байна. Нутаг дэвсгэрээ хөршийн дарангуйллаас хамгаалж, байгалиа цэвэр хадгалж чадсан нь монголын соёл иргэншлийн томоохон ололт амжилт болсон билээ.

XX зууны үед Монгол улсын эргэн тойрон байдал эрс өөрчлөгджээ. Хятадад засгийн эрхэнд байсан Манжийн хаад тухайн үед өөрсдийн хөгжүүлж байсан нүүдлийн уламжлалын сүүлчийн дархан цаазтай газар болж үлдсэн Монголыг сонирхосон сонирхолоо алдав. Хань үндэстэнд ууссан Чин улсын ордныхон Монголыг хятадуудын колончлолоос хамгаалж чадахаа больж, тус улсыг соёл, экологийн сүйрлийн ирмэгт хүргэжээ. Чин улсынхан Монголыг сүүлчийн өмөг түшиг хэмээн үзэж чадахгүй боллоо. 1911 онд Хятадад Синьхайн хувьсгал болж, Манжийн эзэнт улс сүйрсний ачаар Монгол улс эзэнт улсын хэсэг болох талаар авсан үүргээсээ чөлөөлөгджээ. Жавзандамба хутагтын санаачлагаар Орос улс Монголын ивээн эзэрхэгч улс болжээ. 1917 онд Оросын эзэнт улс бутарч, 1919 онд Хятадын талаас цэргийн шахалт үзүүлсний дараа нийт Монголын хуралтайн үзэл санаа гарч ирэв. Буддын шашин гадны түрэмгийлэлтэй нүүр учирч эсэргүүцэх хүчингүй байсан учир Чингис хааны эзэнт улсын алдарт түүхийн дурсамж түүхийн тавцанд дахин гарч ирэв. Монголын тулгуур нутгаас хэдэн зуун жилийн өмнө тарсан монгол хэлт үндэстэн ястан оршин суудаг Орос, Хятадын нутагт нийт Монгол улс байгуулах гэсэн үзэл дэлгэрч эхэллээ. Хэрэг дээр энэ хөдөлгөөн бол Буриадыг Орос улсаас, Өвөр Монголыг Хятад улсаас салгаж, Монголтой хамт нийт Монгол улсыг байгуулах гэсэн хөдөлгөөн байсан билээ. Буриад, Өвөр Монголын пан монголч үзэлтнүүдийн нэгдсэн цэрэг Монгол улсыг эзлэх хүртэл төлөвлөгөөг зохиож байсан юм. Ийм бодлого явуулахдаа пан монголч үзэлтнүүд ламын хаант засаглалын үндэс сууринд аюул учруулж байсан учир тэд засгийн газраас шалтгаалж байв. Хятадын түрэмгийллийн үед хүртэл Барон Унгерн Богд гэгээний хаант улсыг байгуулах нэрийдлээр л Монголд Азийн дивизийг дагуулан ирж чадсан юм. Харин Богд гэгээн Унгернийг дуудсаны бүүр өмнө өөрийн төлөөлөгчөө Зөвлөлт Орос улсад илгээсэн билээ. Чухам энэ үеэс Монголын түүхийн шинэ үе шат эхэлсэн юм.

1921-1990 онд Монгол улс бол ЗСБНХУ-ын цэрэг, эдийн засаг, улс төр, соёлын их хэмжээний тусламж (үүний хамт үзэл суртлын шахалт) дэлхийн хоёрдугаар дайныг дуустал Монгол улс коммунист туршилт хийх талаар ЗСБНХУ-ын цорын ганц түнш байлаа. 1946 оны 1 дүгээр сар хүртэл хууль эрхийн дагуу Хятадын хэсэг нь болж байсан Монгол улс бас коммунист Орос улсад ч ивээл, хамгаалалт олж байсан юм. Монгол нь хөрш улсуудыг тогтоон барьж, хүлээн зөвшөөрсөн хил хязгаартай, өөрийн сүлд тэмдэгтэй олон улсын өвөрмөц субъект боллоо. Монголын удирдагчид Кремлийн стратегчдээс суралцаж, Алс Дорнодын орнуудын талаархи улс төрийн бодлогыг боловсруулахад, мөн ирээдүйн зөвлөлт-хятад-монголын хүчирхэг коммунист эвслийн үндэс суурь тавихад нөлөө үзүүлэх боломжтой байв. Үүний зэрэгцээ Коминтерн, БОК (б)Н, Зөвлөлт засгийн газар болон МАХН, БНМАУ-ын хоорондын элэгсэг дотны харилцаа нь харилцан сэжиглэх, нууц явуулга хийх уур амьсгалтай давхцаж байв. ЗСБНХУ-д А.Амар, П.Гэндэнг оролцуулан Монголын олон удирдагчдыг залхаан цээрлүүлсэн юм. Монгол улс ЗСБНХУ болон фашистын эсрэг бүлэглэлийн талд орж, Дэлхийн хоёрдугаар дайнд ялалт байгуулахад ихээхэн нэмэр оруулжээ. Орос, Монгол хоёрыг төр улс болон хүмүүсийн хоорондын олон арван жилийн нягт хэлхээ холбоо, армиудын дайчин хамтын ажиллагаа, нийтийн дайсны эсрэг цэргийн талбарт асгаруулсан цус зэрэг холбож байна. Үүнээс гадна залхаан цээрлүүлэлт, өөрөөр сэтгэгчдийг дарах бодлого, зогсонги байдал зэрэг тоталитар дэглэмийн нийтийн гай гамшиг бас холбож байна.

Дэлхийн хоёрдугаар дайны үеийн Монгол улсын байр суурийг ялалт байгуулсан орнууд харгалзан үзсний үр дүнд 1946 оны эхээр Хятад улс БНМАУ-ыг тусгаар тогтносон улс хэмээн хүлээн зөвшөөрч, дараа нь ЗСБНХУ, БНМАУ-ын хооронд найрамдал, харилцан туслалцах тухай гэрээнд гарын үсэг зурав. ЗСБНХУ-ын идэвхтэй дэмжлэгээр БНМАУ 1961 онд НҮБ-ын гишүүнээр элсэв.

Дайны дараахи Зөвлөлт-Монголын хамтын ажиллагаа нь шинэ асуудал бий болгов. Хятадын “сөрөг хүчин зүйл” үгүй болсон явдал нам, аж ахуйн удирдах боловсон хүчинд тэжээврийн сэтгэл санаа төрүүлж, бүтээлч санаачлагагүй ажиллахад хүргэв. Монгол улс дэлхийд тусгаар тогтносон улсын статус олсны дараа ХХ зууны үеийн геополитикийн хамгийн ноцтой аюултай үе шатанд орсон нь хачин сонсогдож магадгүй. Гэтэл энэ нь тийм юм. Тус оронд тал нутгийг их хэмжээгээр хагалах, хүчээр хамтрал байгуулах, аж үйлдвэржүүлэлт явуулах, бүхнийг төр улсын гарт хуримтлуулах, төлөвлөлтийн дагуу хөгжих, социалист уралдаан зарлах, өөрчлөн байгуулалт хэрэгжүүлэх зэрэг Зөвлөлтийн бүх туршлагыг хуулан авах кампанийг явуулж

байлаа. Тиймэрхүү туршилтыг үүнээс өмнө ч хийж байсан боловч тэдгээр нь дотоодын нөөц хүчинд тулгуурлаж, хэрэггүй болохоо түргэн харуулж, соёл иргэншлийн хувьд аюул учруулаагүй байв. Харин эдгээр шинэ санаачлага нь гаднын хөрөнгө оруулалт, тусламжинд үндэслэгдэж байлаа. Үүний уршгаар тус орны дээд удирдагчид тусгаар тогтнолоо алдахад бэлэн болов. БНМАУ нь Ази, Африк, Латин Америкийн тэр үедээ гартаа авч чадаагүй улс орны хувьд үзмэр жишээ болж байсан учир л тус улсын тусгаар тогтнолыг хадгалсан юм.

80-аад оны эцсээр ЗСБНХУ дуурайлгамаар сайхан шинж чанараа бүрэн алдсан болохоор Монгол улс түүнийг дагах ямар ч сонирхолгүй болж, өөрийн асуудлаа бие даан шийдвэрлэх хэрэгтэй боллоо. Монгол улс Хятадын Тяньаньмэн талбайн туршлагыг ч дагахгүйгээр 1990 оны гуравдугаар сард "хилэн" хувьсгалын замаар явав. Сүүлийн арван жилд тус орон гадны чиг бодлого, өөрийн соёл иргэншлийн дотоодын эх үүсвэр эрэн сүвэгчилж нарийн ээдрээтэй зам туулжээ. Тус улс урьдын адил хөрш орнуудаас эрс ялгаатай ертөнц болон үлдээд байна.

Монголын түүхэнд Орос улс Оросын түүхэнд Монгол улс ямагт чухал байр эзэлдэг байв. Хоёр улсын нэр хүнд, тусгаар тогтнол, хил хязгаар бүрэлдэн тогтсон явдал нь харилцан нөлөөлөлтэй юм. Хоёр улс орон бие биедээ нөлөөлж байж өдий хүрлээ. Цаашдаа ч тийм болно.